



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 06 сарын 11 өдөр

Дугаар 218

Улаанбаатар хот

“Худалдаа хөгжлийн банк” ХХК-иас гадаадын
хөрөнгийн бирж дээр гаргах үнэт цаасыг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 17.3 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 83 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээдээс гадаадын зах зээлд гаргах үнэт цаасыг бүртгэх тухай журам”-ын 1.3, 3.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Худалдаа хөгжлийн банк” ХХК-ийн гадаадын хөрөнгийн зах зээл дээр нийтэд санал болгон гаргаж буй 1,000,000,000 /нэг тэрбум/ ам.доллар хүртэлх үнийн дүн бүхий өрийн бичгийг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Т.Жамбаажамц/-т зөвшөөрсүгэй.

2. Энэхүү тогтоолын 1-д зааснаар Хороо нийтэд санал болгон гаргах дээрх үнэт цаасыг бүртгэсэн нь тухайн үнэт цаасанд өгч байгаа баталгаа биш болохыг тэмдэглэсүгэй.

3. Гадаад улсын зах зээлд үнэт цаас гаргах үйл ажиллагаатай холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Худалдаа хөгжлийн банк” ХХК /Б.Мэдрээ/-д үүрэг болгосугай.

1/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 83 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээдээс гадаадын зах зээлд гаргах үнэт цаасыг бүртгэх тухай журам”-ын 4.1-д заасны дагуу үнэт цаасыг гадаадын хөрөнгийн зах зээл дээр байршуулсан тухай болон арилжаалагдаж буй үйл явцын талаар хагас жил тутамд Хороонд тайлагнаж байх;

2/ Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны санхүүгийн үр дүнгийн болон нийтэд санал болгон өмнө нь гаргаж байсан үнэт цаасны төлбөрийн талаарх бодитой мэдээллээр хөрөнгө оруулагчдыг хангаж, тэдгээрийн хууль ёсны эрхийг хангаж ажиллах.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000226